



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Иргэний нисэхийн үндэсний төвийн Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2025/002/НА-СТА-ТӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Баянхонгор 2025 он</p>	<p>Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат</p> <p>Утас: 99007576 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: М.Алтантуяа</p> <p>Утас: 99061861 Цахим хаяг: altantuyam@audit.gov.mn</p> <p>Аудитор: Н.Бүнчинсүрэн</p> <p>Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsuren@audit.gov.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

310 дугаар байр, Лувсанданзанжанцангийн
өргөн чөлөө 3 дугаар гудамж, Номгон 1 дүгээр баг,
Баянхонгор сум, Баянхонгор аймаг, 64101
Утас: (976) 70442584

Цахим шуудан: procurement_bayankhongor@audit.gov.mn

2025.03.15 № 2/85
танай _____ -ны № _____ -т

ИРГЭНИЙ НИСЭХИЙН ҮНДЭСНИЙ
ТӨВИЙН ХАРЬЯА БАЯНХОНГОР
НИСЭХ БУУДЛЫН ДАРГА
Д.МӨНХЖАРГАЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Иргэний нисэхийн үндэсний төв Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Иргэний нисэхийн үндэсний төв Баянхонгор аймаг дахь Нисэх буудлын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан.

Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцлон тэмдэглэсэн хэсэг

Байгууллагын удирдлага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус байгууллагын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

5020403

d:\2025 он\бичиг хэрэг\тоот\2. а4-албан тоот.docx

Тайлант онд өөрийн орлогоор 10,500.0 мянга, Иргэний нисэхийн ерөнхий газраас татаас санхүүжилтийн орлого 1,237,409.6 мянган төгрөгийн орлого, 1,247,909.6 мянган төгрөгийн зардал батлагдаж, гүйцэтгэлээр 14,281.7 мянган төгрөгийн орлого төвлөрч 1,166,520.6 мянган төгрөгийг зарцуулж, 1,892,581.8 мянган төгрөгийн ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Засгийн газрын 2021 оны 136 дугаар тогтоолоор батлагдсан “Иргэний нисэхийн аюулгүй байдлын журам”-ын 36 заалтыг 98.6 хувьтай гэж үнэлсэн байна

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан. Танилцахад материаллаг буруу илэрхийлсэн зүйл илрээгүй.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР  Б.МӨНХБАТ



Хоёр. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

(төгрөгөөр)			
Мөрийн дугаар	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ХӨРӨНГӨ	0	0
1.1	Эргэлтийн хөрөнгө	0	0
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	29,418,248.55	39,517.76
1.1.2	Дансны авлага	4,509,802.00	3,666,669.60
1.1.3	Татвар, НДШ – ийн авлага	17,454.53	1,725,167.29
1.1.4	Бусад авлага	1,894,143.73	1,323,582.00
1.1.6	Бараа материал	52,728,096.50	60,347,444.92
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	516,038.00	584,000.00
	Эргэлтийн хөрөнгийн дүн	89,083,783.31	67,686,381.57
1.2.1	Үндсэн хөрөнгө	1,021,535,100.79	2,790,055,772.59
1.2.2	Биет бус хөрөнгө	1,050,690,984.79	1,032,895,311.21
1.2.7	Хойшлогдсон татварын хөрөнгө	7,729,456.77	192,441,237.91
	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,079,955,542.35	4,015,392,321.71
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	2,169,039,325.66	4,083,078,703.28
2.1.1.3	Татварын өр	230,268.00	0
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	388,168.17	112,856.90
	Богино хугацаат өр төлбөрийн дүн	618,436.17	112,856.90
2.2	Өр төлбөрийн нийт дүн	618,436.17	112,856.90
2.3	Эздийн өмч	1,703,099,408.77	1,633,381,084.60
2.3.1	Өмч: - төрийн	1,030,960,000.00	1,030,960,000.00
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	672,139,408.77	602,421,084.60
2.3.9	Хуримтлагдсан ашиг	465,321,480.72	2,449,584,761.78
	Эздийн өмчийн дүн	2,168,420,889.49	4,082,965,846.38
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	2,169,039,325.66	4,083,078,703.28

2.2 Аудит хийсэн дэлгэрэнгүй орлогын тайлан

(төгрөгөөр)			
Мөр	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1.1	Үндсэн үйл ажиллагааны орлого	0	0
1.1.1	Борлуулалтын орлого	6,878,343.27	11,752,479.60
	Буулт хөөрөлтийн орлого	3,712,127.27	4,650,280.00
	Газрын техник үйлчилгээний орлого	3,166,216.00	7,102,199.60
	Борлуулалтын орлогын дүн	6,878,343.27	11,752,479.60
1.2	Борлуулалтын өртөг	1,147,873,865.90	1,522,321,299.55
	Бичиг хэрэг	2,295,091.11	2,981,459.44
	Албан конторын зардал	2,398,266.60	1,561,636.37
	Шатахуун	56,169,465.21	60,546,439.40
	Үндсэн цалин	278,367,479.73	373,212,131.98
	Илүү цаг	3,359,453.35	25,950,370.28
	Амралтын мөнгө	32,502,171.60	40,543,577.50
	Цалингийн бусад нэмэгдэл	144,702,449.85	152,520,537.61
	Үндсэн ба нэмэгдэл цалингийн нийт дүн	458,931,554.53	592,226,617.37
	Хоолны үнийн хөнгөлөлт	67,364,999.99	119,099,999.99
	Нийгмийн даатгалын зардал (Үйлдвэрлэл)	70,076,395.56	92,916,860.26
	Сэлбэг засвар-Барилга	33,263,024.42	44,150,554.61
	Сэлбэг засвар-Автомашин	12,776,418.14	8,732,663.64
	Сэлбэг засвар-Аэродром	9,143,088.64	27,649,204.79
	Сэлбэг засвар -ТТ	15,037,532.53	24,133,269.06
	Сэлбэг засвар	70,220,063.73	104,665,692.10
	Цахилгаан	27,601,987.31	44,810,134.58
	Дулаан	35,343,317.58	36,949,954.54
	Усны зардал	0	1,511,780.71

	Холбооны зардал	7,624,702.20	8,398,781.84
	Ашиглалтын зардлын дүн	70,570,007.09	91,670,651.67
	Үндсэн хөрөнгийн элэгдэл	272,949,597.78	348,465,552.38
	Биет бус хөрөнгийн хорогдуулга	17,794,558.35	17,795,673.58
	Элэгдлийн зардлын дүн	290,744,156.13	366,261,225.96
	Үл хөдлөх хөрөнгийн татвар	8,829,778.21	8,829,778.21
	Газрын татвар	546,192.00	520,760.00
	Тээврийн хэрэгслийн татвар	0	1,116,464.00
	Хөрөнгийн даатгал	6,192,504.00	6,940,038.00
	Татвар, даатгалын зардлын дүн	15,568,474.21	17,407,040.21
	Хөдөлмөр хамгаалал	13,881,847.77	19,085,440.58
	Дотоод сургалтын зардал	1,130,000.00	900,000.00
	Сургалтын зардлын дүн	1,130,000.00	900,000.00
	Дотоод томилолт	12,820,057.63	30,180,489.31
	Албан томилолтын зардлын дүн	12,820,057.63	30,180,489.31
	Харуул хамгаалалт	1,311,200.00	4,430,027.26
	Цэвэрлэгээний зардал	5,424,453.66	3,761,246.82
	Гал команд	4,813,921.17	7,357,181.82
	Аудит баталгаажуулалтын зардал	233,600.00	3,600,000.00
	Үйлдвэрлэлийн бусад зардал	3,920,311.51	3,669,290.99
1.3	Нийт ашиг (алдагдал)	-1,140,995,522.63	-1,510,568,819.95
1.4	Үйл ажиллагаа (Борлуулалт, ерөнхий удирдлага)-ны зардал	3,000,000.00	271,600.00
	Аудит баталгаажуулалтын зардал	3,000,000.00	271,600.00
1.5	Үндсэн үйл ажиллагааны ашиг (алдагдал)	-1,143,995,522.63	-1,510,840,419.95
2	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)	868,847,644.95	3,403,422,240.01
2.6.1	Бусад үйл ажиллагааны бус орлого	931,879,827.05	3,506,237,750.11
	Хүүгийн орлого	20,444.45	132,055.60
	Бусад үйл ажиллагааны бус орлого	1,737,200.00	0
	Санхүүжилт орлого	864,750,000.00	1,122,711,470.35
	Систем хоорондын тооцоогоорх орлого	65,372,182.60	2,380,419,824.14
	ҮХ-н дотоод хөдлөлийн борлуултын олз	0	2,974,400.00
2.6.2	Бусад үйл ажиллагааны бус зардал	63,032,182.10	102,815,510.10
	Тэтгэмж	1,000,000.00	5,337,000.00
	Түлшний хөнгөлөлт	2,200,000.00	2,400,000.00
	Банкны үйлчилгээний зардал	181,300.00	82,000.00
	Эмнэлэг үйлчилгээний зардал	0	4,160,000.00
	Үйл ажиллагааны бус бусад зардал	2,044.68	13,205.59
	Систем хоорондын тооцоогоорх зардал	59,648,837.42	90,823,304.51
2.3	Үндсэн бус үйл ажиллагааны ашиг (алдагдал)-ын дүн	868,847,644.95	3,403,422,240.01
3	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	-275,147,877.68	1,892,581,820.06
4	Татварын дараах ашиг (алдагдал)	-275,147,877.68	1,892,581,820.06
5	Ердийн ажиллагааны ашиг (алдагдал)	-275,147,877.68	1,892,581,820.06
6	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-275,147,877.68	1,892,581,820.06

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

(төгрөгөөр)

Д/д	Үзүүлэлт	Өмч	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-ний үлдэгдэл	1,030,960,000.00	672,139,408.77	465,321,480.72	2,168,420,889.49
3	Залруулсан үлдэгдэл	1,030,960,000.00	672,139,408.77	465,321,480.72	2,168,420,889.49
9	2023 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	1,030,960,000.00	672,139,408.77	465,321,480.72	2,168,420,889.49
10	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0	0	0	0
11	Залруулсан үлдэгдэл	1,030,960,000.00	672,139,408.77	465,321,480.72	2,168,420,889.49

12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0	0	1,892,581,820.06	1,892,581,820.06
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0	0	0	0
14	Өмчид гаргасан өөрчлөлт	0	-69,718,324.17	91,681,461.00	21,963,136.83
17	2024 оны 12 - р сарын 31-ний үлдэгдэл	1,030,960,000.00	602,421,084.60	2,449,584,761.78	4,082,965,846.38

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

(төгрөгөөр)

Д/д	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0	0
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	881,277,286.26	1,152,392,263.36
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	2,160,738.00	13,770,840.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	864,750,000.00	1,136,900,000.00
1.1.6	ҮҮА-ны бусад мөнгөн орлого	14,366,548.26	973,992.14
1.1.6.1	Банк хоорондын гүйлгээ	0	747,431.22
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	877,085,625.11	1,181,903,049.75
1.2.1	Ажиллагчдад төлсөн	441,659,872.75	620,577,482.34
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	129,156,868.09	131,924,607.13
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	118,610,985.00	150,865,465.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	38,495,856.11	60,115,666.80
1.2.5	Хүүний төлбөрт төлсөн	1,876.51	13,205.57
1.2.6	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	66,747,520.00	71,383,080.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	52,159,998.18	61,199,680.19
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0	48,081,760.38
1.2.9	ҮҮА-ны бусад мөнгөн зарлага	30,252,648.47	36,994,671.12
1.2.9.1	Банк хоорондын гүйлгээ	0	747,431.22
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	4,191,661.15	-29,510,786.39
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	20,444.45	132,055.60
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	20,444.45	132,055.60
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	20,444.45	132,055.60
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	4,212,105.60	-29,378,730.79
4	Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ	4,212,105.60	-29,378,730.79
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	25,206,142.95	29,418,248.55
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	29,418,248.55	39,517.76

2.5 Техник, эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2023 оны гүйцэтгэл	2024 оны төсөв		зөрүү	Хувь
		Төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА	866,923,018.7	1,247,909,600.0	1,166,520,580.0	81,389,020.0	93.5
НИЙТ УРСГАЛ ЗАРДАЛ	866,923,018.7	1,247,909,600.0	1,166,520,580.0	81,389,020.0	93.5
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	866,923,018.7	1,247,909,600.0	1,166,520,580.0	81,389,020.0	93.5
Цалин, хөлс болон нэмэгдэл урамшил	541,053,806.9	783,327,400.0	730,416,140.0	52,911,260.0	93.2
Үндсэн ба нэмэгдэл цалин	473,688,806.9	608,011,000.0	581,079,000.0	26,932,000.0	95.6
Унаа хоолны хөнгөлөлт	67,365,000.0	131,039,400.0	119,099,990.0	11,939,410.0	90.9
Гэрээт ажлын цалин		44,277,000.0	30,237,150.0	14,039,850.0	68.3
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	58,795,304.0	102,988,600.0	73,677,300.0	29,311,300.0	71.5
Тэтгэврийн даатгал	35,028,568.1	66,582,800.0	43,172,420.0	23,410,380.0	64.8
Тэтгэмжийн даатгал	5,279,036.6	7,833,200.0	7,251,120.0	582,080.0	92.6
ҮОМШ-ийн даатгал	8,502,265.5	10,549,400.0	9,417,580.0	1,131,820.0	89.3
Ажилгүйдлийн даатгал	907,766.8	2,356,600.0	1,257,800.0	1,098,800.0	53.4
Эрүүл мэндийн даатгал	9,077,667.0	15,666,600.0	12,578,380.0	3,088,220.0	80.3
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,177,554.1	90,752,000.0	90,682,800.0	69,200.0	99.9
Гэрэл, цахилгаан	29,999,904.1	49,092,000.0	49,031,210.0	60,790.0	99.9
Түлш, халаалт	38,877,650.0	40,000,000.0	39,996,050.0	3,950.0	100.0

Цэвэр, бохир ус	1,300,000.0	1,660,000.0	1,655,540.0	4,460.0	99.7
Хангамж, бараа материалын зардал	74,993,852.0	83,757,900.0	85,925,810.0	-2,167,910.0	102.6
Бичиг хэрэг	1,680,000.0	3,392,500.0	3,231,900.0	160,600.0	95.3
Тээвэр, шатахуун	58,732,000.0	65,292,100.0	65,292,000.0	100.0	100.0
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	8,295,952.0	9,000,000.0	8,828,910.0	171,090.0	98.1
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	3,582,400.0	2,500,300.0	5,000,000.0	-2,499,700.0	200.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,703,500.0	3,573,000.0	3,573,000.0	0.0	100.0
Нормативт зардал	17,285,000.0	0.0	0.0	0.0	0.0
Нормын хувцас, зөөлөн эдлэл	17,285,000.0	0.0		0.0	0.0
Эд хогшил, урсгал засварын зардал	81,959,455.0	111,443,100.0	111,632,980.0	-189,880.0	100.2
Багаж, техник, хэрэгсэл	30,872,890.0	50,523,200.0	50,713,540.0	-190,340.0	100.4
Тоног төхөөрөмж	8,340,390.0	20,868,200.0	20,868,200.0	0.0	100.0
Автомашин	9,531,520.0	7,872,700.0	7,872,400.0	300.0	100.0
Аэродром	6,805,600.0	13,333,100.0	13,523,750.0	-190,650.0	101.4
Гал унтраах зардал	6,195,380.0	8,449,200.0	8,449,190.0	10.0	100.0
Хөдөлмөр хамгааллын зардал	16,044,315.0	20,181,400.0	20,181,000.0	400.0	100.0
Урсгал засвар	35,042,250.0	40,738,500.0	40,738,440.0	60.0	100.0
Томилолт, зочны зардал	13,985,100.0	32,393,700.0	32,372,300.0	21,400.0	99.9
Дотоод албан томилолт	13,985,100.0	32,393,700.0	32,372,300.0	21,400.0	99.9
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,482,070.2	27,602,700.0	27,891,550.0	-288,850.0	101.0
Харуул, хамгаалалтын зардал	1,468,700.0	3,630,000.0	3,629,960.0	40.0	100.0
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		2,718,000.0	2,718,000.0	0.0	100.0
Үл хөдлөх хөрөнгийн татвар	8,829,778.2	8,830,100.0	8,919,770.0	-89,670.0	101.0
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,263,600.0	3,350,000.0	3,896,600.0	-546,600.0	116.3
Даатгалын үйлчилгээ	6,192,500.0	7,008,900.0	7,008,000.0	900.0	100.0
Тээврийн хэрэгслийн татвар		1,117,200.0	1,116,460.0	740.0	99.9
Газрын төлбөр	546,192.0	768,500.0	520,760.0	247,740.0	67.8
Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	181,300.0	180,000.0	82,000.0	98,000.0	45.6
Бараа үйлчилгээний бусад зардал	5,475,876.5	2,784,200.0	2,024,700.0	759,500.0	72.7
Бараа үйлчилгээний бусад зардал	4,345,876.5	1,884,200.0	1,124,700.0	759,500.0	59.7
Сургалт семинар	1,130,000.0	900,000.0	900,000.0	0.0	100.0
Дотоод сургалт	1,130,000.0	900,000.0	900,000.0	0.0	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		12,860,000.0	11,897,000.0	963,000.0	92.5
Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг		12,860,000.0	11,897,000.0	963,000.0	92.5
Ажил олгогчоос олгох нэг удаагийн тэтгэмж		8,700,000.0	7,737,000.0	963,000.0	88.9
Эмчилгээний төлбөр		4,160,000.0	4,160,000.0	0.0	100.0
НИЙТ ОРЛОГЫН ДҮН	871,370,258.0	1,247,909,600.0	1,151,181,690.0	96,727,910.0	92.2
Буулт, хөөрөлтийн орлого	2,160,738.0	4,000,000.0	6,817,520.0	-2,817,520.0	170.4
Бусад орлого	4,459,520.0	6,500,000.0	7,464,170.0	-964,170.0	114.8
Татаас санхүүжилтын орлого	864,750,000.0	1,237,409,600.0	1,136,900,000.0	100,509,600.0	91.9

Гурав. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 1,145.1 мянган төгрөгийн 3 алдаа зөрчил илэрснээс 400 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт , 745.1 мянган төгрөгийн алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлэв.

3.1 Төлбөрийн акт

1. Нягтлан бодогч нь Улаанбаатар хот руу нормын хувцас авах ажлаар явахад нь томилолтын ирэх, очих хугацааг 1 хоногоор бөглөсөн байхад 3 хоногоор тооцож 400.0 мянган төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү бодож олгосон томилолтын 400.0 мянган төгрөгийг нягтлан бодогчоор төлүүлж орон нутгийн төсөвт төвлөрүүлэх төлбөрийн акт тогтоов.

3.2 Зөвлөмж

1. Тухайн оны 8 сард 1 албан хаагчийн цалинг 484.0 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээнд илүү мэдээлсэн байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 дэх "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" Нийгмийн даатгалын Ерөнхий хуулийн 32 дугаар зүйлийн 32.2-т "Ажил олгогч дараах үүрэг хүлээнэ:", 32.2.2-т "орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх;" гэсэн заалтыг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Илүү мэдээлсэн 484.0 мянган төгрөгийг тухайн албан хаагчийн цалин түүнтэй адилтгах орлогоос суутган тооцож залруулах зөвлөмжийг хүргүүлэв.

2.Тайлант оны эхэнд нийгмийн даатгалын байгууллагаас 37.8 мянган төгрөгийн авлагатай байсан бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээгээр 172,775.0 мянган төгрөгийг мэдээлж 172,998.4 мянган төгрөгийг төлж оны эцэст 261.1 мянган төгрөгийн авлагатай байхад санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 дэх "Үнэн зөв байх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5 дахь "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах" гэсэн заалтыг зөрчсөн байна..

Шийдвэрлэсэн нь: Санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй 261.1 мянган төгрөгийг 2025 оны 1 улирлын тайланд залруулж бүртгэж суутган тооцоо хийх зөвлөмжийг хүргүүлэв.

Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд худалдан авах ажиллагааг хуулийн дагуу зохион байгуулаагүй 1 зөрчил илэрч 36949.9 мянган төгрөгийн алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмжийг хүргүүлээ.

1. Тайлант онд түлш халаалтын зардалд 40,000.0 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 36,949.9 мянган төгрөгийн нүүрс худалдан авсан бөгөөд тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 34.1 дэх "Захиалагч нийт төсөвт өртөг нь харьцуулалтын аргаар худалдан авч болох төсөвт өртгийн дээд хязгаараас хэтрээгүй бараа, ажил, үйлчилгээний тендер шалгаруулалтыг харьцуулалтын аргаар цахим системд үнийн санал дуудаж зохион байгуулж болно", Засгийн газрын 2024 оны 02 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр шууд болон харьцуулалтын аргаар худалдан авч болох бараа, ажил үйлчилгээний төсөвт өртгийн дээд хязгаар"-т заасан хэмжээг зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа холбогдох хууль тогтоомжийг дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж байх зөвлөмжийг хүргүүлэв.

Дээрх акт, албан шаардлагын биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

9. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

(мянган төгрөг)

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Нягтлан бодогч нь Улаанбаатар хот руу нормын хувцас авах ажлаар явахад нь томилолтын ирэх, очих хугацааг 1 хоногоор бөглөсөн байхад 3 хоногоор тооцож 400.0 мянган төгрөгийг илүү олгосон байна	1	400.0	1	400.0				
Тухайн оны 8 сард 1 албан хаагчийн цалинг 484.0 мянган төгрөгийг нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээнд илүү мэдээлсэн байна.	1	484.0					1	484.0
Тайлант оны эхэнд нийгмийн даатгалын байгууллагаас 37.8 мянган төгрөгийн авлагатай байсан бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийн мэдээгээр 172,775.0 мянган төгрөгийг мэдээлж 172,998.4 мянган төгрөгийг төлж оны эцэст 261.1 мянган төгрөгийн авлагатай байхад санхүүгийн тайланд авлагаар тусгаагүй байна.	1	261.1					1	261.1
Дүн	3	1,145.1	1	400.0			2	745.1

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Тайлант онд түлш халаалтын зардалд 40,000.0 мянган төгрөг батлагдаж гүйцэтгэлээр 36,949.9 мянган төгрөгийн нүүрс худалдан авсан бөгөөд тендер зарлаагүй шууд худалдан авалт хийсэн байна.	1	36,949.9					1	36,949.9
Дүн	1	36,949.9					1	36,949.9

-----oOo-----